

**“МОНГОЛПРОСЦВЕТМЕТ” ТӨҮГ-ЫН “БАЙГУУЛЛАГЫН
ХАРИУЦЛАГЫН ДААТГАЛ” ХИЙЛГЭХ ТУХАЙ ЗАР**

2024.09.11

Даатгуулагч: “Монголросцветмет” ТӨҮГ-ын захиргаа, Ажилчдын байр, Спорт заал, “Бор Өндөр” УБҮ, “Шижир алт” АҮ.

Даатгалын хугацаа : Гэрээ байгуулснаас хойш 1 жилийн хугацаанд хүчин төгөлдөр байна.

Даатгалын зүйл: “Монголросцветмет” ТӨҮГ-ын үйл ажиллагааны улмаас гуравдагч этгээдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулснаас үүсэх хуулийн хариуцлага байна.

Даатгалын үндсэн эрсдэл:

-“Монголросцветмет” ТӨҮГ-ын эзэмшил, өмчлөлийн талбай (Тусгай зөвшөөрөлтэй талбайнууд, орон сууцын барилга) даатгуулагчийн санамсар болгоомжгүй үйлдлийн улмаас гуравдагч этгээдийн амь нас, эрүүл мэндэд хохирол учруулах, эд хөрөнгөд хохирол учруулах;

-Даатгуулагчийн ажиллах орчин нөхцөлд гарах гэнэтийн осол, аваараас болж гуравдагч этгээдэд учирсан хохирол;

-Даатгуулагчийн хөдөлмөр хуваарилалтын буруу зохион байгуулалт, буруу удирдамжаас болж гуравдагч этгээдэд учирсан хохирол;

-Даатгуулагчийн үйл ажиллагаандаа ашиглаж байгаа техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн эвдрэл тасалдал доголдлоос болж гуравдагч этгээдэд учирсан хохирол;

-Даатгуулагчийн ажилтны хариуцлагагүй байдал, үйлдлийн улмаас гуравдагч этгээдэд учруулсан хохирол.

Даатгалын үнэлгээ-1,000,000,000 /нэг тэрбум/ төгрөг

Даатгуулагчийн өөрийн хүлээх хариуцлага- Байхгүй

БҮРДҮҮЛЖ ИРҮҮЛЭХ МАТЕРИАЛУУД:

- *Албан бичиг /Үнийн санал, нийлүүлэх хугацаа, төлбөрийн нөхцөлийг дурдсан байх/*
- *Байгууллагын гэрчилгээ, НӨАТ-ын гэрчилгээ, Татварын өргүй тухай тодорхойлолт*
- *Хариуцах этгээдийн итгэмжлэл, холбогдох мэйл, утасны дугаар*

ҮНИЙН САНАЛ ХҮЛЭЭН АВАХ СҮҮЛИЙН ХУГАЦАА: 2024.09.19-НЫ 15:00 ЦАГААС ӨМНӨ

**ШУУД ХУДАЛДАН АВАЛТТАЙ ХОЛБООТОЙ ТОДРУУЛГА БОЛОН ҮНИЙН САНАЛ
ХҮЛЭЭН АВАХ АЖИЛТНЫ ХОЛБОГДОХ ХАЯГ:**

**ХУДАЛДАН АВАЛТ, БОРЛУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН:
Э.ДЭЛГЭРМАА /DELGERMAA@MONROS.MN/**

УТАС: 11-450-060 , ДОТУУР ДУГААР- 185